



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

### Техникийн хорооны бүрэлдэхүүн батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.9.12 дахь заалт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан Техникийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмын 2.2, 5.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хорооны бүрэлдэхүүнийг доор дурдсанаар баталсугай.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, чанарын хяналтын асуудлаар мэргэшсэн шинжээч, судлаачаар:

1/Лхагвасүрэн Хоролсүрэн-АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирал, судлаач

2/ Батсүх Бурмаа- Улсын гуравдугаар төв эмнэлгийн уламжлалтын эмч

3/ Дамба Наранзул- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанд тархвар судлаач

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ санхүүгийн хяналтын асуудлаар мэргэшсэн санхүүгийн шинжээч, судлаачаар:

1/ Түвдэндорж Ариунтуяа- АШУҮИС-ийн Захиргаа, хүний нөөцийн албаны дарга, судлаач

2/ Бямбаа Дэнсмаа- Хавдар судлалын үндэсний төвийн Эдийн засаг, төлөвлөлтийн албаны дарга

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөллөөр:

1/Лувсандорж Ундармаа- Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эмнэлзүйн албаны дарга

2/Өнөрсайхан Анир- Өлзийдэн ХХК-ийн санхүү эрхэлсэн дэд захирал

Даатгуулагчийн эрх ашгийг төлөөлсөн холбоо, төрийн бус байгууллагын

төлөөллөөр:

1/Лувсан Мөнх-Эрдэнэ-АШУҮИС-ийн Эрүүл мэндийн бодлогын тэнхмийн эрхлэгч, судлаач

2/ Жаргалсайхан Бямбасүрэн-АШУҮИС-ийн Санхүү, эдийн засгийн газрын эдийн засагч

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан техникийн хорооны нарийн бичгийн даргыг томилох, техникийн хорооны үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах, техникийн хорооны орон тооны бус гишүүдэд холбогдох журмын дагуу урамшууллыг тооцож олгохыг Ажлын алба /Т.Батмөнх/-нд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан холбогдох хууль, тогтоол, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, хариуцлагатай ажиллахыг техникийн хорооны орон тооны бус гишүүдэд даалгасугай.

4.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан техникийн хорооны үйл ажиллагаанд шаардлагатай тооцоо судалгаа, нэмэлт баримт, мэдээ, мэдээллийг тухай бүр холбогдох хугацаанд нь ирүүлж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Т.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ЧИНЗОРИГ

